



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 290

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах  
тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 448 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, спортын яамны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Биеийн тамир, спортын хөгжлийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймаг/нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2015 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг 2015 оны 08 дугаар сарын 20-ны дотор Эрүүл мэнд, спортын яамны Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Оюунсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Ганчимэг/-д үүрэг болгосугай.

САЙД




Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080996



Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 07 сарын 31 өдрийн  
290 дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Э.Оюунсүрэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга: Д.Нямхорол, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн

Гишүүд: Р. Байгалмаа, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Эрүүл мэндийн байгууллагын хяналт, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Д.Баясгалан, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Салбарын удирдлага, мэдээллийн тогтолцооны бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

Г.Базархүрэл, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн

А.Өнөржаргал, Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн мэргэжилтэн

М.Оюунчимэг, Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн мэргэжилтэн

Д.Ганзориг, Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн

С.Мөнх-Эрдэнэ, Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн

Ч.Зулцэцэг, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Тогтолцооны судалгаа, статистикийн хэлтсийн дарга



Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 07 сарын 31 өдрийн  
290 дугаар тушаалын 2 дугаар  
хавсралт

ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМНЫ ХАРЬЯА ТӨВ ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН  
ТӨВ, БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХӨГЖЛИЙН ТӨВ, БҮСИЙН ОНОШИЛГОО,  
ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ, АЙМАГ/НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР ТӨВИЙН 2015  
ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГҮЙЦЭТГЭЛИЙН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

#### 1. Үндэслэл:

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 448 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах.

#### 2. Зорилго:

ЭМСЯ-ны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Биеийн тамир, спортын хөгжлийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймаг/нийслэлийн Эрүүл мэндийн газруудын 2015 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмжөөр хангах.

#### 3. Хамрах хүрээ

- Төсвийн ерөнхийлөн захирагчаас төлөөлөн хэрэгжүүлэгч (Аймаг, нийслэлийн Засаг дарга)-тай байгуулсан гэрээний хэрэгжилт
- Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагч (ЭМСЯ-ны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн ерөнхий захирал, Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн захирал ) -тай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт
- Эрүүл мэндийн сайдаас харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн ерөнхий захиралтай байгуулсан Хөдөлмөрийн гэрээний хэрэгжилт
- Тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, үр дүн
- Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт , үр дүн
- Байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн биелэлт, үр дүн
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт
- Хэрэглэгчийн үнэлгээ
- Харьяа эрүүл мэнд, спортын байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын хяналт, шалгалтын үр дүн
- Шилэн дансны хуулийн хэрэгжилт

#### 4. Үр дүн:

- ЭМСЯ-ны харьяа эрүүл мэндийн болон спортын байгууллагуудын 2015 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн дүн ЭМСЯ-ны Удирдлагын зөвлөлийн хуралаар танилцуулагдаж, үнэлгээнээс гарсан санал, зөвлөмжийг эрүүл мэнд, спортын байгууллагуудад хүргэгдсэн байна.